



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/908

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 126 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зорилтот бүлгийн хүүхдийн эрүүл, аюулгүй орчныг сайжруулах, хөгжил, хамгааллыг сайжруулахад 5000 000 /Таван сая/ төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 5 000 000 төгрөг /Таван сая/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 5.26-д тусгагдсан “Зорилтот бүлгийн хөгжил хамгааллыг сайжруулах” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 24-ний өдрийн
А/908 дугаар захирамжийн хавсралт



ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ
САЙЖРУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт /төг/
1	Зорилтот өрхийн хүүхдүүдэд дулаан хувцсаар хангах	20	100000	2 000 000
2	Хүүхдийн сүлд модны наадам	150	20000	3 000 000
	Нийт			5 000 000

-oOo-